

БАТЛАВ
ДАРГА Ч.НЭРГҮЙ

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

**БУЛГИЙН ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖИЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт /
гэрээний нэр:
Тендер шалгаруулалт /
гэрээний дугаар:

“Булаг, рашааны эхийг хашиж хамгаалах, тохижуулах”
ажил

БОХНСЗ-2.2.8/2019

Чойбалсан хот
2019 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2019.04.01

Тендер шалгаруулалтын дугаар: БОХНСЗ-2.2.8/2019

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “*Булаг, рашиааны эхийг хасиж хамгаалах, тохиижуулах*” ажил гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим *Төрийн худалдан авах ажиллагааны системээр зарлагдааж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын/ www.tender.gov.mn дээр байгаа/ дагуу зохион байгуулж байна.*

/Цахим тендерийн урилга 50,000 төгрөг/

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:

Багц-1: Дашибалбар, Гурванзагал, Сэргэлэн Хөлөнбуйр, Баянтүмэн сум / Энгэр булаг, Гурван булаг, Нүхний булаг, Амгалан булаг /- 25,000,0

Багц-2: Матад сум Нарангийн булаг -15,000,0

Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд:

2.2.1. Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохиижилт

Үнийн саналыг **2019 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө ирүүлэх бөгөөд нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2019 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн 10 цаг 10 минутад** нээнэ.

Орон нутгийн давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баг,
Аймгийн ЗДТГ-ын 3 дугаар байрны 2 дугаар давхар.
Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар
Утас: 7058-3058
Факс: 7058-4058

Цахим шуудан: info@umch.dd.gov.mn
Цахим хуудас: www.umch.dd.gov.mn, www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь, төсөв;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) ТШӨХ-т заасан бусад шаардлагатай мэдээлэл.
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцгчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

| Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ | |
|--|--|
| ТОӨЗ-НЫХОЛБОГДОХЗААЛТ | Шалгуур үзүүлэлт |
| ТОӨЗ 1.1 | <p>Тендерт оролцогч нь <i>Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлаас санхүүжих 40,0 сая төгрөгийн төсөв өртөгтэй “Булаг, рашааны эхийг хамгаалах, тохиижуулах”</i> ажил гүйцэтгэх үнийн саналыг дараахь мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • 2018 оны санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; • Борлуулалтын хэмжээ: 2017, 2018 оны борлуулалтын орлогын дундаж нь төсөвт өртгийн 50%-аас багагүй байна. • Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд төсөвт өртгийн үнийн 50 хувиас багагүй дүнтэй тухайн ажилтай ижил төстэй ажил ядаж нэг удаа гүйцэтгэсэн байх. /туршлагын мэдээлэл, гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, акт/; • Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баталгаажуулсан байх/ • Татварын байгууллагын тодорхойлолт • Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт • Шүүхийн байгууллагын тодорхойлолт • Харилцагч банкны тодорхойлолт • Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртгийн дүнгээс 30 хувиас багагүй байх /банкны тодорхойлолт, дансны үлдэгдэл/ • Тохиижилтийн ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, дүрмийг мөрдлөг болгох, ашиглагдах бараа, материал нь холбогдох чанарын шаардлага болон энэхүү тендерийн техникийн тодорхойлтуудыг хангах тухай мэдэгдэл, • Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу тохиижилтийн ажилд ашиглах Монгол улсын гарал үүсэлтэй бараа, материалын жагсаалт гаргаж ирүүлэх, <p>Тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна. Дурдсан мэдээлэл, холбогдох баримтыг ирүүлээгүй нь тендерээс татгалзах үндэслэл болно.</p> |
| ТОӨЗ 1.2 | <p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><i>Багц-1: Дашибалбар, Гурванзагал, Сэргэлэн Хөлөнбуйр, Баянтумэн сум / Энгэр булаг, Гурван булаг, Нүхний булаг, Амгалан булаг - 25,000,0</i></p> <p><i>Багц-2: Матад сум Нарангийн булаг -15,000,0</i></p> |

| | |
|-----------------|---|
| | Оролцогч тендерийн маягтад сонирхож буй багц тус бүрийн үнийн санал болон нийт үнийн саналыг тусгана. Багц тус бүрийн үнийн санал тусгаагүй тендерээс татгалзана. |
| ТОӨЗ 2.1 | <p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p style="text-align: center;"><i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баg, Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газар</i></p> <p style="text-align: center;">Утас: 7058-3058 Факс: 7058-4058</p> <p style="text-align: center;">Цахим шуудан: <i>info@utmch.dd.gov.mn</i> Цахим хуудас: <i>www.utmch.dd.gov.mn, www.tender.gov.mn</i> <i>Ш/Х-250</i></p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ:</p> <p style="text-align: center;"><i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баg, Орон нутгийн өмчийн газар</i></p> <p>Тендерийн нэр: “<i>Булаг, рашааны эхийг хашиж хамгаалах, тохиижуулах</i>” ажил</p> <p>Тендерийн дугаар: БОХНСЗ-2.2.8/2019 /Оролцогчийн нэр, холбоо барих хаяг/</p> |
| ТОӨЗ 2.1 | <p>Тендер хүлээн авах хаяг:</p> <p style="text-align: center;"><i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баg Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газар, ахлах мэргэжилтэн Ч.Баттулга Ш/Х-250</i></p> <p>Хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр Цаг: 10 цаг 00 минут</p> |
| ТОӨЗ 2.2 | <p>Тендерийн нээлт хийх газар:</p> <p style="text-align: center;"><i>Дорнод аймгийн Хэрлэн сумын 10-р баg Аймгийн Засаг даргын Тамгын газрын 3-р байр, 2-р давхар Орон нутгийн өмчийн газрын хурлын өрөө</i></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: 2019 оны 04 дүгээр сарын 08-ний өдөр Цаг: 10 цаг 10 минут</p> |
| ТОӨЗ 2.3 | Сангийн сайдын 2018 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын дагуу давуу эрх тооцно . Тендерт оролцогч давуу эрх эдлэх хүсэлт, нотлох баримт, холбогдох мэдээллийг тендерийн хамт ирүүлнэ. |

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАГЦ-1

БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ
АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2019.02.19

Хэрлэн сум

Байршил:

- 1.Дашбалбар сүм Энгэрийн булаг /сүмын төвөөс зүүн хойш 30 км/
- 2.Гурванзагал сүм Гурваны булаг /сүмын төвөөс зүүн хойш 32 км/
- 3.Сэргэлэн сүм Энгэрийн булаг /сүмын төвөөс хойш 50 км /
- 4.Хөлөнбуйр сүм Нүхний булаг /сүмын төвөөс баруун хойш 25 км /
- 5.Баянтүмэн сүм Амгалан булаг /сумаас зүүн урагш 47 км/

Булгийн эхийг хашиж хамгаалах ажил хийх арга технологи, техникийн шаардлага

1.Техникийн шийдэл

Булгийн эхийг хашиж хамгаалахад дараах үндсэн шаардлагуудыг удирдлага болгохыг зөвлөж байна.

Үүнд:

1. Булгийн эх нь малын хөлөөс бүрэн хамгаалагдсан байх
2. Булгийн ундарга, эхийг хөндөж муутгахгүй байх
3. Булгийн ундаргад тулалт үүсгэхгүй байх
4. Төмөр хийц, материал сонгож бат бөх хийх
5. Хүйтний улиралд булгийг ашиглах боломжтой байх
6. Булгийн эхийг хамгаалахдаа нэг хийц загварыг сонгох

1.Хамгаалах арга

Булгийн эхийг хамгаалах хашааг $24 \times 26\text{m}^2$ хэмжээтэй төмөр хийц материалыар нийт 100 метр урттай хийнэ. Булгийн ус цуглуулах талбайн хэмжээнээс хамааран хашааны хэлбэр 4 тал буюу тойрог байж болно. Хашааг $1*2 \text{ cm}^2$ өргөн, хөндлөвчийг $1*4 \text{ cm}^2$ хөндий төмрөөр гагнаж хийнэ.

Хашааны өндөр 120 см,

Шонгийн нийт урт 180 см

Шон хоорондын зай 200 см,

Хашааны сараалж хооронд 15 см,

Хашааны төмөр шонгийн диаметр 8-10 см-ийн голчтой төмөр трубагаар хийж, дээд талыг битүүлж, зэврэлтээс хамгаалж төмрийн будгаар будна. Шонг 50 см гүнд суулгаж, зэвэнд идэгдэж урвалд орохоос хамгаалан байгалийн чулуугаар чигжикж цементэлнэ.


Булгийн урсацын доод талд буюу булгийн хөлд 80 см өргөнтэй гадагш онгойдог, явган хаалга хийж хогийн сав байрлуулна.

Булгийн эхийг хамгаалсан хашаан дотор 10-аас доошгүй мод тарьсан байна.

Усны нөөцийг бохирдлоос хамгаалах талаарх сурталчилгааны самбарыг 80×60 хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр хийж, хашаанд гагнаж бэхлэнэ.


Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна. Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авна.

**БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ
ХАШААНЫ ЗУРАГЛАЛ**



/хашааны зураг/

Yavgan hunii halganii zurag



/явган хүний хаалга/

АЖЛЫН ДААЛГАВАР

БАГЦ-2


БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ, ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР
/Матад сум Нарангийн булаг/

2019.02.19


Хэрлэн сүм

| № | Хийгдэх ажлууд | Тавигдах шаардлага |
|---|---|---|
| 1 | Рашааны эхийн хашааг сэргээн засварлах | -Рашааны эхийн хашааны суурийг сэргээн засварлаж, төмөр хашааны нурж унасан хэсгийг гагнаж, суурийн хэсгийг бөхөлж хийнэ. Өнгө үзэмжийг сайжруулан зориулалтын будгаар будна. |
| 2 | Рашаанд орох хэсэгт хамгаалалтын хашаа хийх | Хамгаалалтын хашаа нь 60x5 метрийн харьцаатай/130 метр урт/ өндөр нь 1.2 метр байна. Хашааны шонг 50 см гүнд суулгаж, цемент бетон зуурмагт суулгана. |
| 3 | Рашаанд орох хэсэгт сүүдрэвч, ширээ, сандал | -Сүүдрэвч нь 2x2.5 метрийн хэмжээтэй 1,8 метрийн өндөртэй 2 ширхэг байна. -Сүүдрэвчийг бат бөх төмрөөр хийж, газарт 0.5 м гүн цемент бетон зуурмагт суулгана. -Сүүдрэвчийн ширээг 1.0x0.6 метрийн харьцаатай төмрөөр хийж, газарт 50 см гүн цемент бетон зуурмагаар бэхлэн суулгана. -1 сүүдрэвчинд 1.0 метрийн урттай, 0.4 метрийн өргөнтэй 2 ширхэг сандал хийнэ. -Сүүдрэвч, сандал, ширээг төмрийн будгаар будна. -Сүүдрэвчийн дээврийг 0.6 мм зузаан дээврийн өнгөт төмрөөр хийнэ. -Сүүдрэвч, ширээ, сандал нь үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангасан хурц өнцөг, ирмэггүй байна. |
| 6 | Мэдээллийн самбар 2 ширхэг | -Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэм, хог хаягдал, галын санамж байрлуулах мэдээллийн 2 ширхэг самбар хийнэ. - Самбарын хүрээг 20x40 мм тэгш өнцөгт төмрөөр гагнан хийж, 1000x1000 мм хэмжээтэй 2 мм зузаан гөлмөн төмрөөр битүүлж гагнаж бэхэлнэ. -Самбар нь 2 тулгуур багантай байна. Багана нь 2.5 метрийн урттай 80x80 мм квадрат төмрөөр хийж, самбарын хүрээтэй гагнаж бэхэлнэ. -Самбарын тулгуур баганыг газарт 50 см гүнд цемент бетон зуурмагт суутгана. Тулгуур баганы газарт суух хэсэгт |

| | | |
|--|--|--|
| | | хөндлөвч төмөр гагнасан байна. - Самбарт тавигдах мэдээллийг сайн чанарын гадна зориулалтын хэвлэл эсвэл гэрэл ойлгогчтой будаг ашиглаж хийнэ. Самбарын 2 талд мэдээллийг байрлуулна. -Самбарт байрлуулах мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч бэлтгэн байрлуулна. |
|--|--|--|




**БУЛАГ, РАШААНЫ ЭХИЙГ ХАШИЖ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ
ХАШААНЫ ЗУРАГЛАЛ**
/Матад сум Нарангийн булаг/



/хашааны зураг/

Нарангийн рашааныг тохижуулах зураглал



Тав. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Нэргүй танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт засны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Зургаа. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана. 4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|--|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна. 7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |

| | |
|---|--|
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх | 9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 11. Үе шатны ажлын хуваарь | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардлагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |
| | В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ |
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарыт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 13. Алданги | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарыт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги ² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |
| | Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ |
| 14. Ажил дуусгах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| 15. Хүлээж авах | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гарана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гарана.
- 20. Гүйцэтгэлээ с чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Долоо. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

| | |
|-----------------|--|
| ГЕН 2.1 | Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Тендерийн урилгад заасан нэр болон дугаар]</i> |
| ГЕН 2.1 | <p>Ажил нь <i>[төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i>-аас бүрдэнэ.</p> <p>Ажлын талбай нь <i>[байришил]</i>-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.</p> |
| ГЕН 3.1 | Төслийн менежер нь <i>[томилогдсон этгээдийн нэр, хаяг]</i> |
| ГЕН 4.1 | <p>Ажил эхлэх өдөр <i>[огноо]</i></p> <p>Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[огноо]</i>⁴</p> |
| ГЕН 7.1 | Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[моо]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана. |
| ГЕН 9.1 | Чанарын баталгаат хугацаа <i>[моо]</i> хоног байна. |
| ГЕН 13.1 | <p>Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.⁵</p> <p>Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[хувь]</i> байна.</p> |
| ГЕН 17.1 | <p>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i>-ны дотор гаргаж өгнө.</p> <p>Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.</p> |
| ГЕН 19.1 | Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно. |

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

⁵ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

Найм.ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

/...../ *ажлын үзүүлэлт*

Дугаар № /...../

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилсан тохиролцож _____ оны _____ сарын _____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____
хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай,
_____ суурь, _____ хана, _____
хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар,
тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан,
цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад
ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____ -ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын
_____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]